



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 338

Номгон

Төрийн тахилгат “Их Богд Хайрханы тэнгэрийг  
тайх” ёслол зохион байгуулах тухай

Иргэд, олон нийтэд байгаль дэлхий, нутаг усаа хамгаалах, хүндэтгэх үндэсний үзлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 85 дугаар зарлигаар батлагдсан “Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 131 дүгээр зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 72 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3. дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 43 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн тахилгат **“Их богд хайрханы тэнгэрийг тайх ёслол”**-ыг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Луу цагт тус аймгийн Богд сумын 3 дугаар багийн нутаг Далан түрүүний голд зохион байгуулсугай.


2. Төрийн тахилгат **“Их Богд хайрханы тэнгэрийг тайх ёслол”**-ын бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын комисс, дэд комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ёслолын бэлтгэл ажлыг сайтар хангаж, тахилгын үйл ажиллагааг байгаль дэлхий хүн зоныг баясгахад чиглүүлж, ёслолын дэг жаяг, дарааллаар хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг комиссын дарга Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Баянмөнх) -д үүрэг болгосугай.


4. Ёслолын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг гүйцэтгэлээр тооцож, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

621010863

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлого хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын  
27-ны өдрийн А/338 дугаар захирамжийн 1 дүгээр  
хавсралт



**ТӨРИЙН ТАХИЛГАТ ИХ БОГД ХАЙРХАНЫ  
ТЭНГЭРИЙГ ТАЙХ ЁСЛОЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

**Нэг. Төрийн тахилгат Их Богд хайрханы тэнгэрийг тайх ёслолын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах дэд комисс**

Комиссын дарга Л.Баянмөнх –Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Комиссын нарийн бичгийн дарга Э.Ганзориг –Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд Т.Норов - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /зөвшилцсөнөөр/

Д. Энхжаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Хоёр. Төсөв, санхүү хариуцсан дэд комисс:**

Дэд комиссын ахлагч С.Байгалмаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Сарангарав -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Рэнцэндагва – Аймгийн Татварын хэлтсийн дарга

**Гурав. Ёслол, хөтөлбөр, аж ахуйн дэд комисс:**

Дэд комиссын ахлагч Л.Мандал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Г.Нэмэхбаяр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа

Ц.Энхтөр - Боловсрол, соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Пүрэвдагва - Хөгжимт драмын театрын дарга

Б.Баянжаргал - Гон Ган дэдлин хийдийн хамба лам

2.

Б.Бат-Өлзий-Их Богдын байгалийн цоцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Р.Пүрэвсүрэн -Түүх угсаатны зүй, байгалийн түүхийн музейн захирал

Ц.Түвшинжаргал –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Батхүү - Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн Захирагч, хурандаа

Б.Оюунбаатар -Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ж.Уламбаяр - “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний гүйцэтгэх захирал

Д.Содномсамдан -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн

Д.Өлзийбаяр Богд сумын Засаг дарга

Р.Батжаргал Жинст сумын Засаг дарга

Б.Мөнхсайхан Баянговь сумын Засаг дарга

О.Мөнхбат Баянлиг сумын Засаг дарга

**Дөрөв. Дэг журам, харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах дэд комисс:**

Дэд комиссын ахлагч Б.Оюутболд - Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

Гишүүд: Ж.Алтангэрэл - Онцгой байдлын газрын дарга, Хурандаа

Ц.Батхүү - Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч, Хурандаа

Р.Мэндбаяр -Тагнуулын хэлтсийн дарга, Дэд хурандаа

Н.Бямбадорж - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Н.Энхжаргал -Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Тав. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын дэд комисс:**

Дэд комиссын ахлагч Д.Дэлгэрсайхан - Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан

Гишүүд: М.Батбаяр - “Баянхонгор -Хүн үүслийн өлгий” Аялал жуулчлалын холбооны тэргүүн

Ш.Эрдэнэзул - Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан